

1

НИЙГМИЙН БОДЛОГЫН
ЧИГЛЭЛЭЭР

1.1. “БИЕ ЭРҮҮЛ ХЭНТИЙЧҮҮД”

● НЭГДСЭН ЭМНЭЛГИЙГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАЛАА

Нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүдийн тасагт орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017-2019 онд нийт 35 сая төгрөгийн засварын ажлыг хийж, 176.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангаснаар жирэмсэн болон амаржсан ээжүүд, эмэгтэйчүүд, эмч эмнэлгийн ажилтнуудын эрүүл ахуйн халдвар хамгааллын орчин сайжирсан. Мөн дутуу төрсөн нярайд сурфактанд эмчилгээг хийх боломж бүрдэж нэг нярайд тусламж үзүүлээд байна. 2017 онд төрөх, эмэгтэйчүүдийн тасагт эх ургийн монитор, хяналтын монитор, фототерапийн аппарат, дуслын автомат шахуурга, нярайн түнхний ЭХО зэргийг 54.7 сая төгрөгийн, 2018 онд Япон улсын буцалтгүй тусламжаар 23,5 сая төгрөгний өртөг бүхий ургийн монитор, ОНХСангаас 50 сая төгрөгийн ургийн гажиг илрүүлэх 3D/4D ЭХО аппарат, 2019 онд НҮБ-ын Хүн амын сан, УТХО-аар нярайн амьсгалын 2 аппаратаар тус тус хангаж, бага жинтэй нярайд сурфактант эмчилгээг хийж эхлээд байна.



● ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУСТ ЭЭЛТЭЙ КАБИНЕТ БАЙГУУЛЛАА

Нэгдсэн эмнэлгийг түшиглэн «Өсвөр үед ээлтэй кабинет»-ыг байгуулж, зорилтот бүлгийнхэнд мэдээ мэдээлэл авах орчныг бүрдүүлэн, «Итгэлтэй утас» ажиллуулж, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг тогтмолжууллаа. Тус кабинетыг НҮБ-ын Хүн амын санхүүжилтээр 12 сая төгрөгний тоног төхөөрөмжөөр хангасан байна. 2018-2019 онд зорилтот бүлгийнхэнд 28 удаагийн сургалт зохион байгуулж 6138 хүүхэд, эцэг эх, асран хамгаалчдыг хамруулсны үр дүнд өсвөр насныхны жирэмслэлт 2017 онд /14-19 насны/ 2,9% байсан бол 2019 онд 2,3% болж буурсан. Мөн 20 хүртэлх насны үр хөндөлт 2017 онд 9,5% байсан бол 2019 онд 4,3% болж, БЗДХӨвчин 0.41% /53/-иас 0.14%/22/ болж тус тус буурсан байна.



● 43650 ХҮНИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛЖЭЭ

Аймгийн эрүүл мэндийн газраас 2017-2019 оны хагас жилийн байдлаар ДЭМБ, ЭМЯ, НЭМҮТ зэрэг дээд шатлалын болон орон нутгийн төрийн болон төрийн бус 15 аж ахуй нэгж, албан байгууллагуудтай хамтран нийт 25 удаагийн өдөрлөг, 186 удаагийн сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 43650 иргэдийг хамруулан, 9150 ширхэг гарын авлага, 3150 ширхэг зурагт хуудас хэвлүүлэн түгээжээ.





● "ЦАХИМ ХУРЛЫН ТАНХИМ"-ААР ҮЙЛЧИЛЖ ЭХЭЛЛЭЭ

Эрүүл мэндийн газрын «Цахим хурлын танхим»-аар Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Гуравдугаар эмнэлэг болон Нэгдсэн эмнэлэг, 22 сум, тосгодын төвүүд цахимаар холбогдож, тусламж үйлчилгээг сайжруулан эмчилгээний чиглэлээр зөвлөгөө аван ажиллаж байна. 10000 хүн амд ноогдох зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 18,1 промилль /10.7%/83 тох/, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9,2 промилль /11.1%/ 86тох/ байна. “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр элэгний өвчлөл 8.3%-иар, элэгний шалтгаант нас баралт 1,9%-иар тус тус буурчээ.




● УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНД ТҮШИГЛЭН ӨВЧЛӨЛӨӨС СЭРГИЙЛЭХ 14 УДААГИЙН ӨДӨРЛӨГТ 17 СУМЫН 5310 ИРГЭНИЙГ ХАМРУУЛЛАА

Уламжлалт анагаах ухаан, хүүхдийн сэргээн засах төвтэй хамтран “Эрүүл аж төрөх Монгол ухаан”, “Өвчнөөс урьдчилан сэргийлэх Монгол арга” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад ЕБС-ийн 5-11 дүгээр ангийн 20 сурагчийг хамруулан бэлтгэсэн бол Уламжлалт анагаах ухаанд түшиглэн өвчлөлөөс сэргийлэх чиглэлээр 14 удаагийн өдөрлөгт 17 сумын 5310 иргэнийг хамрууллаа. Тухайлбал, иргэдэд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх Монгол арга ухаан сэдвийн хүрээнд 2017-2019 онд нийт 60 сургагч багшийг бэлтгэн хамтран ажиллаж байна. 38 удаагийн сургалтад 1140 иргэн, 14 удаагийн өдөрлөгт давхардсан тоогоор 4170 иргэнийг хамруулжээ.



● НЭГДСЭН ЭМНЭЛЭГ АХМАД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ САЙЖРУУЛЖЭЭ

Нэгдсэн эмнэлгийн ахмадын тасаг 6 ортой байсныг 2018 онд 10 ортой болгож, эмчийн тоог нэгээр нэмэгдүүлэн хоёр их эмчийн орон тоотой ажиллаж байна. Мөн сэргээн засах тасагт ХБ-Хүүхдийг эмчилж сувилах хоёр ортой өрөөг ДЗМОУБ-ын Бор-Өндөр-2 ОНХ-Хөтөлбөрийн санхүүжилт 8 сая төгрөгөөр тохижуулж, боловсон хүчнийг сурган үйлчлүүлэгчид хөдөлгөөн заслын эмчилгээ сувилгааг хүргэж эхэлсэн. Зөвлөх Поликлиникт Ахмад настан, ХБИ-дэд зориулсан чийрэгжүүлэхийн өрөөг тохижуулж, 2019 онд 240 хүнд үйлчлүүлээд байгаа аж. Тэгвэл УАУХСЗТөвийн саам эмчилгээний нэг ээлжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан ажиллуулж, 11 хүүхэд хамрагджээ. Харин аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын өрхийн ЭМТөвүүд 256 хэвтрийн өвчтөнд давхардсан тоогоор 1256 иргэнд гэрийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлээ.



● ХАЛДВАРТ ӨВЧНҮҮД БУУРСАН ДҮН ГАРЛАА

Өсвөр үеийнхний урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулан, БЗДХ-ын илрүүлэг үзлэгийг сайжруулсантай холбоотой зонхилон тохиолдох тэмбүү өвчин 79 буюу 10.000 хүн амд 10.2 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс /18.2/ буурчээ. Зоонозын халдварт өвчний тандалт судалгааг өргөжүүлэн голомтот бүс нутгийг 100% хамруулан гүйцэтгэж, олон улсын судалгааны багтай хамтран судалгаа шинжилгээ хийж хүний нөөцийг чадвахжууллаа. Зоонозын шалтгаант өвчин риккетсиоз 3 буюу 10.000 хүн амд 0.3 промилль байгаа нь 2016 онтой харьцуулбал /1.55/ 5 дахин буурсан үзүүлэлт гарав.



Амьсгалын замын халдвар 2019 онд 38 тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 4.8 промилль байгаа нь 2016 онтой харьцуулбал /102.2/ 21 дахин буурсан үзүүлэлт гарчээ. Пневмококкийн /хатгааны/ эсрэг шинэ вакциныг дархлаажуулалтад амжилттай нэвтрүүлснээр 2016 онтой харьцуулахад томуугийн сайн дурын дархлаажуулалтын хамрагдалт 3 дахин өсжээ.

● “ЭРҮҮЛ МЭНД- ХӨДӨЛГӨӨН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД БҮХ СУМДАД НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРЫН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ЯВУУЛЛАА

Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр 15 сая төгрөгийн санхүүжилтээр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд 2017 онд 13120 хүнийг, 2018 онд 13448 хүнийг, 2019 онд 10000 хүнийг хамруулж, зорилтот бүлгийн хамралтыг 38-40%-тай зохион байгуулснаар 2016 онтой харьцуулахад гурав дахин өссөн үзүүлэлттэй байна.



● ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДЫГ БАЙР, ОРОН СУУЦААР ХАНГАВ

Эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 2017 онд сумдын эрүүл мэндийн төвийн 6 эмчийг, 2018 онд 8 эмчийг байр орон сууцаар хангасан бол 2019 онд сумдын эрүүл мэндийн төвийн эмч нарын 88% нь байраар хангагдаад байна. 2017-2019 онд Түрээсийн орон сууцанд 9 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ипотекийн орон сууцны зээлд 24 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан орон сууцанд орлоо.



● ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЁС ЗҮЙН СУРГАЛТАД ХАМРУУЛЛАА

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран 2017-2019 онд давхардсан тоогоор 1158 эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургалтад хамруулж мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд анхаарсны үр дүнд нь «Ёс зүйн салбар хороо»-нд ирсэн өргөдөл гомдлын тоо өмнөх онтой харьцуулахад 3,4 хувиар буурлаа.



● ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ 23.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЛЭЭ

Өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбарт барилга байгууламж, засвар үйлчилгээнд 17.9 тэрбум, эмнэлгийн тоног төхөөрөмжид 4.5 тэрбум, 24 авто машинаар хангахад 1 тэрбум, нийт 23.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 2017 онтой харьцуулахад 37.6 хувиар нэмэгдэж, компьютер томограф, дижитал рентген, тархины цахилгаан бичлэг, нярайн түнхний ЭХО, ургийн гажиг илрүүлэх ЭХО, мобайл технологи зэрэг аппарат багаж зэрэг сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдээр хангалаа





1.2 БОЛОВСРОЛЫН САЛБАР

● СӨБ-Д 8,7 ТЭРБУМ, СУРГУУЛИУДАД 7,8 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРЖЭЭ



Хэнтий аймгийн Яслийн барилгад 96 сая төгрөгийн их засвар хийж, орчныг сайжруулсан бол Бор-Өндөр, Батноров сум, Бэрх тосгоны цэцэрлэгт яслийн бүлэг нээж 101 хүүхдийг хамруулаад байна.


Боловсролын салбарт 2017-2019 онд Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын зээл тусламжаар 26.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Тухайлбал 3 сургууль, 3 дотуур байр, 1 цэцэрлэгийн өргөтгөл шинээр барьж ашиглалтад оруулсан ба 10 сургууль, 8 цэцэрлэг, 2 сургуулийн дотуур байрт их засвар хийсэн. Үүний үр дүнд цэцэрлэг, сургуулийн суудлын тоо 1763-аар нэмэгдэж, хамрагдалт 2016 онд 94.7 хувь байсан энэ онд 95.8 хувь болж өссөн байна.



2017-2019 онд Мөрөн сумын сургуульд шатар, Бэрх хотын сургуульд физик, Биндэр сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулсан бол 19 сургууль байгалийн ухааны сургалтын зориулалттай мини лабораторийг худалдан авч, хичээл сургалтдаа ашиглаж, байгалийн ухааны сургалтын чанар 3 хувиар ахижээ.



● СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙГ АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАЛАА



Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төвлөрсөн усан хангамжид холбогдсон 6 сургуульд мэдрэгчтэй крант суурилуулах ажил 52.8 хувь, 10 цэцэрлэгт суурилуулах ажил бүрэн хийгдсэн нь усны хэмнэлт, үр дүнтэй зарцуулахад зохих үр дүнгээ өгчээ. Ариун цэврийн байгууламжгүй 16 сургуулиас 6 сургуулийг стандартын ариун цэврийн байгууламжтай болгосноор, 2019 оны байдлаар нийт 12 сургууль, 10 цэцэрлэг гүний худагтай болж, нийт сургуулийн 63.2 хувь, цэцэрлэгийн 47.4 хувь нь усны аюулгүй байдлаар хангагдах нөхцөл бүрдлээ.

● ХЭНТИЙ АЙМГИЙН БҮХ СУРГУУЛЬД “ДЭМЖЛЭГИЙН БАГ”-ИЙГ БАЙГУУЛАВ

ЕБС-д хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2017 онд 206, 2018 онд 182, 2019 онд 298 сурагч суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 2018 онд 90, 2019 онд 59 багш, 79 удирдах ажилтныг хамруулжээ. Үүний дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт өнгөрсөн оноос 106 хүүхдээр буюу 39 хувиар нэмэгдлээ. БСШУСЯ-ны А/292 тоот тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг

ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ийн 3.5 дахь заалтыг үндэслэн Хүүхдийг сургуульд тэгш хамруулан сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь боловсрол эзэмшихэд дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг бүхий "Дэмжлэгийн баг"-ийг бүх сургуульд байгууллаа.



● СӨБ-ЫН СУРГАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛЛАА

2017 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчныг сайжруулах зорилгоор цэцэрлэгүүдийн орчны стандартад үнэлгээ хийхэд аймгийн дундаж 83.7 хувьтай үнэлэгдэж, 27 цэцэрлэг орчны стандартыг 80-аас дээш хувьтай хангажээ. Үнэлгээний мөрөөр төрийн өмчийн 32 цэцэрлэгт "Хүүхэд хөгжил" хөтөлбөрийн санхүүжилтээр жил бүр 500.0 орчим сая төгрөгийн өртөгтэй тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлж, өөрсдийн дотоод нөөц бололцоо, эцэг эх олон нийтийн дэмжлэгтэйгээр 6 цэцэрлэг хашаагаа өндөрсгөх, 12 цэцэрлэг гадна тоглоомын талбайг тохижуулах, 14 цэцэрлэг туршилтын талбай байгуулах, хүлэмж барих зэрэг ажлуудыг хийв.

Үүнчлэн 2018 онд МХЕГ-ын даргын 2017 оны А/179-р тушаалаар батлагдсан "Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм"-ийн дагуу цэцэрлэгүүдийн эдэлбэр газарт үзлэг хийхэд 25 цэцэрлэгийн эдэлбэр газрын хэмжээ стандартын шаардлага хангаж, 9 цэцэрлэгийн газар шаардлагад нийцэхгүй нь тогтоогджээ. Тухайн цэцэрлэгүүдэд холбогдох байгууллагад хандаж, эдэлбэр газрын хэмжээг нэмэгдүүлэх талаар үүрэг өгч хэрэгжилтийг хангуулжээ.

**ОЛОН УЛСЫН ЭКО СУРГУУЛЬ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЛ ГЭРЭГЭНИЙ БОЛЗОЛ ХАНГАСАН
СУРГУУЛНУДААА БАЯР ХҮРГЭЕ.**

Bronze
Eco-Schools
Bronze Award

25. Нийслэлийн ЕБ-ын лаборатори 28-р сургууль	36. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р цэцэрлэг
26. Нийслэлийн ЕБ-ын 23-р сургууль	37. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р цэцэрлэг
27. Нийслэлийн ЕБ-ын Наран сургууль	38. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3-р цэцэрлэг
28. Ховсгол аймгийн Морон сумын Дэлгэрморон цогцолбор сургууль	39. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5-р цэцэрлэг
29. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р сургууль	40. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7-р цэцэрлэг
30. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4-р сургууль	41. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Бамбар цэцэрлэг
31. Хэнтий аймгийн Даваа сум ЕБ-ын сургууль	42. Хэнтий аймгийн Баян-Авсгал сумын цэцэрлэг
32. Хэнтий аймгийн Норовлин сумын ЕБ-ын сургууль	43. Хэнтий аймгийн Бэрх сумын цэцэрлэг
33. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тэмүүжин цогцолбор сургууль	44. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Бинаар цэцэрлэг
34. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургууль	45. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 2-р цэцэрлэг
35. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Мэргэжийн Сургалт Үйлдвэрлэлийн Тов	46. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 3-р цэцэрлэг
	47. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын цэцэрлэг
	48. Хэнтий аймгийн Морон сумын цэцэрлэг
	49. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын цэцэрлэг

**ECO SCHOOLS AWARDS
MONGOLIA 2019**

Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE) -гийн гиш
ОУ-ын Эко сургууль хөтөлбөрийн үнэлсний оператор
Байгаль орчны мэдээлэл сургалтын төв ТББ
Холбоо барих: 88111893.99085775

● НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ ТӨВӨӨС 13000 ГАРУЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД 309 СУРГАЛТ ЯВУУЛЖЭЭ

Төрийн бус байгууллага болон сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн хороодын хамтын ажиллагааг дэмжиж, эцэг, эхчүүдэд зориулсан хүүхэд хүмүүжүүлэх сургалтуудыг зохион байгуулах зорилгоор Аймгийн Засаг дарга "Насан туршийн боловсрол төв"-ийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулан, эцэг эхэд зориулсан сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшлээ. Насан туршийн боловсрол төв нь 2017 онд 58 удаагийн сургалтаар 4325, 2018 онд 184 удаагийн сургалтаар 5764, 2019 онд 67 удаагийн сургалтаар 3107 эцэг эхэд сургалт явуулжээ.



● ДОТУУР БАЙРАНД СУУХ ХҮҮХДИЙН ТОО НЭМЭГДЛЭЭ

Хэнтий аймгийн ЗДТГ, Боловсролын газраас "Тэргүүний дотуур байр"-ыг шалгаруулах уралдааныг жил бүр зохион байгуулж байгаа бөгөөд энэ оны уралдааныг 10 дугаар сард явуулж, «Хан Хэнтий» цогцолбор сургуулийн дотуур байр шалгарч, 1.2 сая төгрөгөөр шагнагдлаа.



Дотуур байрны орчинг гэрийн нөхцөлд ойртуулах, 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж үйлчилгээ үзүүлэх зөвлөмжийг бүх сургуулиудад хүргэснээр 2018 онд 4 сургууль буюу Батноров, Баянмөнх, Баян-Овоо, Хан-Хэнтий цогцолбор сургуулийн дотуур байр шаардлага хангасан төдийгүй дотуур байранд сууж байгаа 6-8 насны хүүхдийн тоо 2018 онд 117 байсан бол 2019 онд 177 болж, 60 тоогоор нэмэгдэв.



● СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙГ ЭКО ОРЧИНТОЙ БОЛГОЛОО

Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх ажлын хүрээнд Тогтвортой хөгжлийн боловсролын хөтөлбөрт нийцүүлэн эко клуб, хичээллүүлэх болон эко сургууль болох зорилгоор олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийг Монгол улсад албан ёсоор хэрэгжүүлэгч Байгаль орчны мэдээлэл сургалтын төвтэй хамтран ажиллаж, хөтөлбөрт аймгийн нийт сургуулиуд бүрэн хамрагдсан. Үүний үр дүнд сургууль, цэцэрлэгүүд байгаль орчноо хамгаалах, болон зөв хэрэглээний дадал эзэмшиж байна. Ингэснээр “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ЭКО СУРГУУЛЬ”-ийн тоо жилээс жилд нэмэгдэж, хоёр сургууль “Мөнгөн гэрэгэ”, 6 сургууль, нэг коллеж “Хүрэл гэрэгэ” болзол хангасан.



Түүнчлэн 2017 оноос эхлэн “Олон улсын Эко сургууль” хөтөлбөрт Хэнтий аймгаас 21 цэцэрлэг хамрагдаж, тухайн ондоо нэг цэцэрлэг аймгийн “Эко байгууллага”-аар шалгарч, нийтдээ 2 цэцэрлэг, 2 сургууль мөнгөн гэрэгэ, 16 цэцэрлэг, 6 сургууль 1 коллеж “Хүрэл гэрэгэ” хүртлээ. Энэ нь Улсын хэмжээнд анх удаа цэцэрлэг “Хүрэл гэрэгэ” авч байгаагаараа онцлогтой юм.

● ЭХ ХЭЛ БИЧГЭЭРЭЭ УЛСДАА ТЭРГҮҮЛЖ БАЙНА

Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар 18 сум, 4 тосгонд эх хэлний салбар зөвлөл байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхээр шилдэг арга туршлагатай 31 багш, 9 сурагчийг хамруулан “Багш сурагч солилцооны хөтөлбөр”-ийг 2017 онд зохион байгуулсан.

Уг хөтөлбөрийн үйл ажиллагаагаар 3844 сурагчдаас бага, дунд, ахлах ангийн эх хэл, бичгийн хөтөлбөрийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, ажлын байр дээрээ хөгжих боломжийг хангасан 70 гаруй багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн бол 7382 эцэг, эх болон иргэд олон нийтэд зөв бичих дүрэм, үндэсний бичгийн анхан, дунд, шатны сургалт зохион байгууллаа.



Эх хэлний салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэн төр захиргааны байгууллага, багш-сурагч-эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж ажилласнаар Хэнтий аймаг монгол хэлний сургалт сайжирч ЭЕШ-ын дүнгээр улсдаа 2017 онд 6, 2018 онд 4, 2019 онд 1-р байрт орсон бол Монгол хэл, бичгийн улсын төрөлжсөн олимпиадын 3-ын даваанд 2017 онд 1 алт, 2018 онд 2 алт, 1 мөнгө, 1 хүрэл, 2019 онд 1 алт, 1 хүрэл, 1 тусгай байр эзэлсэн амжилт гаргалаа.

● 24 СУРГУУЛИЙН СУРАГЧИД 10347 ШИРХЭГ МОД ТАРЬЖЭЭ

Ерөнхий боловсролын сургуулиуд төгсөгчдийн нэрэмжит мод тарих, цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай Аймгийн Засаг дарга сургуулийн захирлуудтай хийж буй үр дүнгийн гэрээнд тусган ажилласнаар аймгийн хэмжээнд 24



сургуулийн 3120 гаруй сурагчид 10 төрлийн 10347 ширхэг мод тарилаа. 2017 онд 10 сургуулийн 2100 төгсөгч 10 төрлийн 2947 мод, 2018 онд 24 сургуулийн 2460 сурагч 9 төрлийн 5680 мод, 2019 онд 9 сургуулийн 1876 сурагч 5 төрлийн 1720 мод тарилаа. Мод жил бүр тарьснаар сургуулиудын эзэмшил газрын 20-30 хувь нь ногоон байгууламжтай болжээ.

● СУРАГЧИД ОЮУН УХААН ХӨГЖҮҮЛЭХ ДУГУЙЛАН СЕКЦЭД ТҮЛХҮҮ ХАМРАГДАЖ БАЙНА

БСШУСЯ-аас багш, сурган хүмүүжүүлэгчдэд секц дугуйлан хичээллүүлсний урамшуулал цалин олгохгүй болсноос хойш сурагчдын дугуйланд хамрагдалт улсын хэмжээнд буурсан. Хэнтий аймагт 2017 онд 25 сургуулийн сонгон, секц, дугуйланд давхардсан тоогоор нийт 12587, 2018 онд 8010, 2019 онд 10872 сурагч хамрагджээ. Тухайлбал, 2017-2018 оны хичээлийн жилд нийт сурагчдын 89,7 хувь хамрагдаж байсан бол 2018-2019 онд 55 хувь болж буурсан. Харин орон нутгаас авч хэрэгжүүлсэн бодлого, зохион байгуулалтын үр дүнд шинэ хичээлийн жилд 74,3 хувь нь сонгон, секц, дугуйланд хамрагдаж, өнгөрсөн оноос 19.3 хувиар ахилаа.



Аймгийн хэмжээнд 2017 онд 10 сургуулийн 430 хүүхэд, 2018 онд 15 сургуулийн 589 хүүхэд, 2019 онд 18 сургуулийн 602 хүүхэд буюу нийт сургуулийн 72 хувь нь сэтгэх чадварын дугуйланд хичээллэж байна. Дугуйланд хичээллэснээр Улсын сэтгэх чадварын ХҮ олимпиадын II-XII ангийн нийт 10 ангилалд 2017 онд 190 хүүхэд, 2018 онд 221 хүүхэд, 2019 онд 385 хүүхэд оролцжээ. 2017 онд төрийн өмчийн 25 сургуульд шатар, даамны секц хичээллүүлж 756 хүүхэд хамрагдсан бол, 2018 онд 873, 2019 онд 1042 буюу жил бүр ахисан үзүүлэлт гарчээ. 2017-2019 онд аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү”, Өсвөрийн аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн, аймгийн аварга шалгаруулах “Ялалтын гараа” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Оюун ухааны спортыг хөгжүүлэх зорилгоор 2018 онд сургууль, цэцэрлэгийн багш нарт “ШАТАР, 100 БУУДАЛ ДААМ”-ын анхан шатны сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 59 багшийг хамруулжээ.

● "БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ" ТӨСЛӨӨС ДАВХАРДСАН ТООГООР 34 СУРГУУЛЬ 320 ШАХАМ САЯ ТӨГРӨГИЙН ДЭМЖЛЭГ АВЧЭЭ

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУЯ-аас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төсөлд 2017 онд 25 сургуулийн төслийн саналаас 9 сургуулийн төсөл шалгарч 47.4 сая төгрөг, 2018 онд 16 сургуулийн төсөл шалгарч 90 сая төг, 2019 онд 9 сургуулийн 11 төсөл дэмжигдэж, 185.1 сая төгрөгийн санхүүжилт авснаар бага боловсролын эх хэлний судлагдахууны чанар 22.4 хувиар ахисан үзүүлэлт гарлаа.



● АМЖИЛТ ҮЗҮҮЛСЭН БАГШ НАРЫГ ГАДААДАД ТУРШЛАГА СУДЛУУЛАВ

2017 оноос хойш 7 багшийг АНУ, БНСУ, ОХУ гэх мэт гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, 195 багш ажиллагсдыг БНХАУ, ОХУ-д туршлага судлуулах аялалд хамруулж дэмжлэг үзүүлснээр мэргэжлийн хичээлүүдийн сурлагын чанарт ахиц гарч байна. Аймгийн төвд мкв нь 850,0 төгрөгийн үнэ бүхий 48 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан бөгөөд уг байранд 7 багшийг хамруулжээ.





● СУРГАЛТЫН ТӨВҮҮД ХАМРАГДСАНААР АМЖИЛТАА АХИУЛЖЭЭ

Аймгийн хэмжээнд математик, англи хэлний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 сургалтын төвийг дэмжин ЭЕШ болон олимпиад, хоцрогдлыг арилгах, багш нарыг чадавхжуулах мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд анхааран хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд 2017 онд 4811 оролцогчоос 1285, 2018 онд 6786 оролцогчоос 2797 сурагч, 2019 онд 2384 оролцогч хүүхдээс 574 хүүхэд шагнал хүртжээ.

Түүнчлэн 2019 онд сурагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Spelling Bee" буюу англи үг үсгэлэх тэмцээн-ийг зохион байгуулж, 15 сургуулийн 6-8-р ангийн нийт 105 сурагч оролцож, шалгарсан 9 сурагчийг сургалтын төвд нэг сар үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгээр шагнасан.



● ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ, ГАДААДЫН УЛС, ОРНУУДАД ТЭТГЭЛГЭЭР СУРЧ ЭХЭЛЛЭЭ

Гадаад хэлний сургалтын төвтэй хамтран ажилласнаар хүүхдүүдийн тоо, идэвх оролцоо жилээс жилд нэмэгдэж, сурагчдын сурлагын ажилтанд эерэгээр нөлөөлж байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд англи хэлний сургалтад 630 сурагч, Солонгос хэлний сургалтад 49 сурагч хамрагджээ. Сургалтад хамрагдсанаар 2017 онд АНУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй "Ирээдүйн залуу манлайлагчид" буюу FLEX хөтөлбөрийн шалгалтад 1 сурагч тэнцэж, АНУ-ын ахлах сургуульд 1 жил үнэ төлбөргүй суралцах солилцооны хөтөлбөрт хамрагдсан бол 2018 онд 4 сурагч, 2019 онд 5 сурагч тус хөтөлбөрийн шалгалтад тэнцэн АНУ-д суралцлаа. Мөн Солонгос хэлний сургалтад хамрагдсан иргэдээс 2018 онд 2 хүн, 2019 онд 3 хүн БНСУ-д гэрээгээр ажиллахаар явж нэг сурагч БНСУ-ын их, дээд сургуульд суралцахаар боллоо.



1.3 СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

● СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ЭРГЭЛТЭД ОРУУЛЛАА

Хэнтий аймгийн соёл урлагийн салбарын 25 нэгж байгууллага тус бүр дунд хугацааны бодлогын баримт бичиг гарган ажиллаж байна. Хэнтий аймгийн хэмжээнд Батширээт суманд “Ёохор -2019 “ОУ-ын наадам, Биндэр суманд “Тогорууны фестиваль” ОУ-ын баяр, Баян-Адрага суманд “Монгол Хатдын наадам”, Батноров суманд “Талын түмэн адуу” Галшар

суманд “Галшар адууны баяр”, Чингис хотод “Чингис фестиваль” зэрэг Эвент арга хэмжээ болж, дээрх үйл ажиллагаануудад нийт 6000 гаруй хүн хамрагдсан төдийгүй Америк, Австрали, Солонгос, ОХУ, Өвөр монгол БНХАУ-аас жуулчид ирж оролцсон нь Монгол орны соёл, уламжлалт ёс заншилтай танилцан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эргэлтэд орууллаа.





● СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЗАСВАРЛАВ

Хан Хэнтий чуулгын шинэ барилгын ажил 2019 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд ирэх оны зургадугаар сард ашиглалтад орох төлөвлөгөөтэй байна. Хуучин барилгын гадна гэрэлтүүлэг, дотор талд 2 танхим засвар хийж 100 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангалт хийн ажиллах орчноо сайжруулжээ. Хөдөө орон нутагт 2018 онд 5 сумын соёлын төвд нийт 780 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн бол 2019 онд Биндэр, Батноров зэрэг сумдын соёлын төвд нийт 388.2 сая төгрөгийн засварын ажил хийжээ. Мөн Сэцэн Ханы ордон музейн үзмэр, дэглэлийг сайжруулж 4 танхимыг витрин гэрэлтүүлэг авч тохижууллаа.

Соёлын ажилтан, уран бүтээлчдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2019 оны байдлаар нийт 6 удаагийн сургалтад 100 гаруй соёл урлагийн ажилтнууд хамрагджээ.



● НОМЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ТОО НЭМЭГДЛЭЭ

2017-2019 онд Номын сангийн фонд баяжуулах ажил жил бүр хийгдэж номын фонд 50 хувиар өсжээ. Бүх нийтээр ном унших хөдөлгөөнийг эрчимжүүлснээр 2017 онд 18870 идэвхтэй гишүүд, 1250 байнгын уншигчтай болж, 43865 ном олгосон бол, 2018 онд 26064 ирэгсэд, 1626 байнгын уншигчдад 47200 ном, 2019 онд 26229 ирэгсэд, 1573 байнгын уншигчдад 39574 ном олгож жил бүр уншигчдын тоо тогтмолжиж байна. Мөн нийтийн номын санг 2019 онд орон нутгийн хөгжлийн сангаас 5.6 сая төгрөгөөр бүрэн дохиолол, хамгаалалт, галын хяналтын системд бүрэн холбож, MNS5742: 2007 стандартын үзүүлэлт 3.5 хувиар ахисан үзүүлэлт гарчээ.



1.4 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР :

● БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АХИЦ АМЖИЛТУУД

"ЭРҮҮЛ МЭНД-ХӨДӨЛГӨӨН-ХӨГЖИЛ" дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр зохион байгуулагддаг хүн амын ББТТСорилын арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, Хэнтий аймаг 2017, 2018 онуудад анх удаа улсын хэмжээнд 2-р байр, тэргүүн байрыг тус тус эзэллээ. 2019 оны сорилын дүнгээр хаврын сорилын хамрагдалт 7.6 хувиар өссөн, А,В үнэлгээтэй 5711 иргэд байгаа нь 2018 онтой харьцуулахад 7.7 хувиар өсжээ.

Мөн Нийтийг хамарсан нийтийн биеийн тамирын арга хэмжээг жил бүр тогтмолжуулан иргэдийн оролцоо, эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг өсөн төлөвшиж байна. 2017, 2018, 2019 онуудад нийтийн биеийн тамир, үндэсний болон спортын төрлүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагаа нэмэгдэж, 71 удаагийн арга хэмжээг зохион байгуулж нийт 26250 гаруй иргэд хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 5 хувиар өссөн дүн гарлаа.

2016 онд аймгийн хэмжээнд нэг фитнес төв, нэг спортын клуб байсан бол 2019 оны байдлаар 3 фитнес клуб, нэг иогийн төв, волейбол, дугуй, бокс, буудлага болон үндэсний спортын төрлөөр нийт 22 спортын холбоо, 5 спортын клуб үйл ажиллагаа явуулж байна.

2016 оноос эхлэн явган аяллыг сумдад зохион байгуулж Баян-Адарга, Биндэр сумд явган аяллын маршруттай боллоо. Өсвөр үеийн шигшээ баг нь 2017 онд спортын 12 төрлөөр дунджаар 250 тамирчин хичээллэж байсан бол 2019 оны байдлаар спортын 15 төрлөөр 297 тамирчин хичээллэж байна.

Улсын нэгдсэн тооллогоор Хэнтий аймгийн 25 ЕБС нийтдээ 29 спорт заалтай гэсэн тоон үзүүлэлт гарсан ба 2019 онд нийт 2.4 тэрбум төгрөгийн УТХО-аар Баянхутаг, Батноров сумдад шинээр спорт заал бүрэн ашиглалтад орж, Дэлгэрхаан, Батширээт сумын спорт заалны барилга, угсралтын ажлууд үргэлжилж байна.

2018 онд нийт 47 удаагийн уралдаан тэмцээнд 835 тамирчин оролцож Алт-110, мөнгө-96, хүрэл-118 нийт 324 багц медаль хүртсэн бол 2019 онд нийт 52 удаагийн уралдаан тэмцээнд 935 тамирчин оролцож алт-169, мөнгө 171, хүрэл 187 нийт 527 багц медаль хүртэж, медалийн чанар, амжилтаа ахиулсан байна.

Сумдад спортын секц дугуйлан хичээллүүлж байгаа боловсон хүчнийг чадавхжуулах, ЕБСургуулиудын захирал удирдлагуудтай биеийн тамир, спортын чиглэлээр хамтран ажиллах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2019 онд ЕБС-ийн биеийн тамирын багш нар төдийгүй, захирал менежерүүдийн дунд сургалт, эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлгүүдийг хоёр удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 197 хүн хамрагдлаа. 2018-2019 оны хичээлийн жилд биеийн тамирын секц дугуйланд 5722 сурагч хичээллэж байгаа нь өмнөх оноос 38%-иар өссөн үзүүлэлт юм.

Хэнтий аймгийн Үндэсний Бөхийн өргөөний газрын асуудлыг 2017 онд шийдвэрлэж, Бөхийн өргөөний шав тавих ёслолыг 2019 оны 08 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.





1.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

● ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨВӨӨР 73 ГЭР БҮЛИЙН 2571 ХҮН ҮЙЛЧЛҮҮЛЖЭЭ

2018 онд Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулж 8.250.000 төгрөгийн тохижилтын ажил хийжээ. Тус төвөөр дамжуулан хосын болон бүлгийн зөвлөгөө, Гэр бүлийг дэмжих үйлчилгээ, эрсдэлтэй бүлгийнхний гэрээр үйлчлэх үйлчилгээ, Гэр бүлийн боловсрол олгох сургалт, цахим зөвлөгөө гэх мэт 6 төрлийн үйлчилгээг 73 гэр бүлийн 2571 хүнд хүргэсэн байна. Мөн сүүлийн 3 жилийн хугацаанд зохион байгуулсан хүүхдийн чуулганаас гарсан 359 санал санаачилгыг шийдвэр гаргах түвшинд хүргэж 13 саналыг орон нутгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрт тусгуулан ажиллаж, үр дүнг нь олон нийтэд хүргэжээ.

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээр 2017, 2018, 2019 онуудад нийт хүмүүнлэг, хандив тусламж, хүүхэд ивээн тэтгэх чиглэлээр 54 удаагийн арга хэмжээг хувийн болон ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулж 22.557.500 мянган төгрөгийн хөрөнгө босгон ажилласан байна. Үүний үр дүнд Хүүхэд хөгжлийн ордны үйл ажиллагаа тогтмолжиж, үйлчлүүлэх хүүхэд, залуусын тоо нэмэгдлээ.



● ХОХИРОГЧ ХАМГААЛАХ БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА

АИТХ-ын 2018 оны 71 дүгээр тогтоолоор хохирогчид цогц үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийг байгууллаа. Тус төвийн байрны засварт 10 сая төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан бөгөөд 2019 онд НҮБХАС-аас 47.313.449 төгрөгийн санхүүжилт авч тохижилт аюулгүй байдлыг цогцоор нь шийдвэрлэж цэвэр бохирын төвлөрсөн системд холбон стандартад нийцсэн тохижилт, үйлчилгээтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. НЦҮТ байгуулагдсанаас хойш нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллуулах цалингийн зардалд 23.261.991 төгрөгийг, кейс үйлчилгээний зардалд 3.039.050 төгрөгийг, төвийг тохижуулахад 71.313.449 төгрөгийг ЗД-ын нөөц хөрөнгө болон ОУ-ын байгууллагын дэмжлэг, улсын төсвөөс гаргаж зарцуулжээ.



1.6 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

БОЛОМЖ БҮРИЙГ АШИГЛАЖ ЧАДДАГ ХЭНТИЙЧҮҮД

● 894 ИРГЭНИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАЖЭЭ

Ажилтай орлоготой өрх дэд хөтөлбөрийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 07 тоот тогтоолоор батлуулсан хэрэгжилтийг хангах үүднээс ажил хайгч болон ажил олгогчийг шууд мэдээллээр ханган байнгын ажлын байранд 666 иргэн, улирлын чанартай ажлын байранд 92 иргэн, түр ажлын байранд 136 иргэн нийт 894 иргэнийг ажлын байраар хангасан. Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 1000 иргэнд, ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 966 иргэнд өгч, 234 өрх, иргэнийг мэргэжил, мэдлэг, ур чадвар олгох сургалтуудад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд зуучлан амьжиргааг нь дээшлүүлжээ.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн ажил олгогчийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдаж гэрээ байгуулсан 6 аж ахуйн нэгж байгууллага ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна. Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн чиглэлээр 2 сумын 12 ахмадын 3.3 сая төгрөгийн төсөл, төлөвлөгөөг хүлээн авч хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадвар өвлүүлэх Ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнчлэн 9 ахмадад аж ахуйн болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 24 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосноор 12 ахмад түр ажлын байранд, 9 ахмад байнгын ажлын байранд ажиллаж байна.



1.7. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

● АХМАДЫН СУВИЛАЛ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ТЭЛЛЭЭ

ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувилал нь орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, зөөлөн эдлэлийн чанарыг сайжруулж, Дэлгэрхаан суман дахь “Аварга тосон” дахь гэр сувилалд тосон эмчилгээний байр, бохирын цооног, цахилгааны ДТП-г 30.0 сая төгрөгийн өртгөөр шинээр барьж, зуны хугацаанд 231 ахмадыг хүлээн авлаа.



● АХМАДЫН ОРДОНТОЙ БОЛЛОО

Аймгийн төвд А зэрэглэлийн бүсэд төвийн шугамд бүрэн холбогдсон 800 гаруй м.кв талбайтай 2 давхар, 700 м.кв эзэмшлийн талбайтай ахмадын ордныг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжууллаа.



Мөн тус ордны урсгал зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэн ажиллаж байна. Энэхүү ордон нь ахмадуудын эрэлт хэрэгцээ, онцлогт тохирсон орчинтой, эрүүл насжилтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн учир ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бүрдсэн.

● АХМАД НАСТАНД СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖЭЭ

Ахмад настанд үзүүлэх асаргаа, сэргээн засах үйлчилгээ эрхлэх хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжих зорилгоор уламжлалт болон орчин үеийн аппарат тоног төхөөрөмж хосолсон сэргээн засах үйлчилгээг өргөжүүлэхээр хүсэлтээ ирүүлсэн хоёр байгууллагатай хамтран зорилтод бүлгийн 92 иргэдийг тус үйлчилгээнд хамруулан 13.702,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. ОНОТХҮйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 16 төслийг хүлээн авч 32 иргэнийг хамруулан 22,500.000 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож амьжиргаанд нь зохих дэмжлэг үзүүлжээ.



● “ТЭГШ ДҮҮРЭН” ХӨТӨЛБӨРИЙГ 3 СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЖ, 68 ӨРХИЙГ МАЛЖУУЛЖЭЭ

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2011 оны 216 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр баталсан билээ. “Тэгш дүүрэн” хөтөлбөрийг 3 суманд хэрэгжүүлж байгаа бөгөөд амьжиргааны түвшин доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 68 өрхийг малжууллаа.

